

## ДАРХАН-УУЛ АЙМАГ

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ТЭРГҮҮЛЭГЧДЭЭС  
БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦААНД  
БАРИМТАЛЖ АЖИЛЛАХ ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
2017-2020 ОНЫ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

2016 ОН

## ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХҮНДЭТ ИРГЭДЭЭ

Төрөлх хотынхоо 55 жилийн ойн өмнөхөн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдээс бүрэн эрхийн хугацаанд баримталж ажиллах үйл ажиллагааны Үндсэн чиглэлийг 5 бүлэгтэйгээр баталж, аймгийн “Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн төслийг иргэд, хөдөлмөрчид, төрийн болон төрийн бус байгууллагуудтайгаа хамтран хэлэлцэж, нийт 8 бүлэг, 11 дэд бүлэг, 139 зорилттойгоор аймгийн ИТХ-аар батлуулан тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж байна.

Дархан-Уул аймгийн Монгол Ардын Намын 2016 оны Орон нутгийн сонгуульд оролцсон “Есөн эрдэнийн мөрийн хөтөлбөр”-ийн 9 бүлэг, 142 арга хэмжээнээс аймгийн “Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т 80 арга хэмжээ нь шууд туссан ба 56 арга хэмжээг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгахаар төлөвлөж байна.

Дархан-Уул аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт:

1. Төрийн удирдлагын бодлогын чиглэлээр 12 зорилт
2. Хууль эрх зүйн бодлогын чиглэлээр 11 зорилт
3. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр 32 зорилт  
Бодлого, төлөвлөлт, зохион байгуулалтын чиглэлээр 11 зорилт  
Дэд бүтцийн чиглэлээр 11 зорилт  
Үйлдвэржилтийн чиглэлээр 10 зорилт
4. Хүнс, хөдөө аж ахуйн бодлогын чиглэлээр 18 зорилт  
Мал аж ахуй чиглэлээр 6 зорилт  
Газар тариалангийн чиглэлээр 7 зорилт  
Хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр 5 зорилт
5. Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлогын чиглэлээр 15 зорилт  
Байгаль хамгааллын чиглэлээр 12 зорилт  
Аялал жуулчлалын чиглэлээр 3 зорилт
6. Нийгмийн бодлогын чиглэлээр 37 зорилт  
Боловсрол, соёл, урлаг, спортын чиглэлээр 16 зорилт  
Эрүүл мэндийн чиглэлээр 9 зорилт  
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр 12 зорилт
7. Санхүү, төсвийн бодлогын чиглэлээр 8 зорилт
8. Гамшгаас урьдчилан сэргийлэх, батлан хамгаалах бодлогын чиглэлээр 6 зорилт тусгагдсан бөгөөд хөгжлийн бодлогын баримт бичиг 4, хөтөлбөр 22, төсөл 4, томоохон бүтээн байгуулалтын ажил 13 тус тус багтсан.

Та бүхэндээ аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдээс бүрэн эрхийн хугацаанд баримталж ажиллах үйл ажиллагааны Үндсэн чиглэл, аймгийн “Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг толилуулж байна.

Аймгийн Иргэдийн  
Төлөөлөгчдийн Хурлын  
Ажлын алба

Аймгийн Засаг даргын  
Тамгын газар



## ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 10 сарын 03 өдөр

Дугаар 3/сд

Дархан

### Үндсэн чиглэл батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ийн "а", 19 дүгээр зүйлийн 19.1, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтуудыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус Гуравдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдээс сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд баримталж ажиллах үйл ажиллагааны Үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.

2. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдээс сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд баримталж ажиллах үйл ажиллагааны Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлыг жил бүр ажлын төлөвлөгөөндөө тусган зохион байгуулж ажиллахыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын хуралдааны 2013 оны "Үндсэн чиглэл батлах тухай" 2/02 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Г.ЭРДЭНЭБАТ

Аймгийн ИТХ-ын 2016 оны  
ээлжит бус Гуравдугаар хуралдааны  
3/02 дугаар тогтоолын хавсралт

## **ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ТЭРГҮҮЛЭГЧДЭЭС БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦААНД БАРИМТАЛЖ АЖИЛЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ**

Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бодлогыг тодорхойлон, түүнийг хэрэгжүүлэхэд иргэд, хамт олны бүтээлч санаачилга, идэвхитэй оролцоонд тулгуурлан ажиллах зарчмыг баримталж, нийгмийн салбаруудыг дэмжиж, иргэдийнхээ аж амьдралыг сайжруулах, Нутгийн өөрөө удирдах ёсыг хөгжүүлэхэд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны Үндсэн чиглэлийн зорилт оршино.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчид 2016-2020 онд аймгаа хөгжүүлэх эдийн засаг, санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд бодлого үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж дараах асуудлуудыг хамруулна.

### **НЭГ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР**

Монгол улсын Үндсэн хуулинд заагдсан хүний эрхийг хангах, гэр бүлийг дэмжих, иргэн бүр эрүүл, боловсролтой, ажилтай, орлоготой байх нөхцөл бүрдүүлэхэд анхаарч, хүн амын дундаж орлоготой хэсгийг нэмэгдүүлж, иргэдийнхээ амьжиргааг сайжруулах оновчтой бодлого тодорхойлоход чиглэгдэнэ.

1.1. Боловсролын салбарын үйлчилгээг тэгш хүртээмжтэй болгож, сургууль, цэцэрлэгийн тоо, хүчин чадал, хамрагдалтыг нэмэгдүүлэн багш, хүүхдийн хөгжил, нийгмийн асуудлыг сайжруулахад чиглэгдсэн хөтөлбөрүүдийг батлан хэрэгжүүлэх

1.2. “Дарханы иргэд-Оюунлаг, Авьяаслаг” хөтөлбөрийг

батлан, хэрэгжилтийг эрчимжүүлж, Дарханчуудын нийтлэг үнэт зүйлс, бахархалыг тодорхойлон иргэдэд сурталчилж, санал санаачилгыг дэмжин ажиллах,

1.3 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, урьдчилан сэргийлэх болон оношилгоо, эмчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийг хангаж, нийгмийн хамгааллыг сайжруулах,

1.4. “Эрүүл-Дарханчууд”, “Спортлог Дарханчууд” хөтөлбөрүүдийг батлан, хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, дадал хандлагад төлөвшүүлэх, нийтийн биеийн тамирыг бүх нийтийн хүртээл болгох бодлого баримтлах,

1.5. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, жижиг дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчид, баялаг бүтээгчдийг дэмжин, өрхийн амьжиргааны чадавхийг дээшлүүлэх,

1.6. Ахмад настны асаргаа, сэргээн засах болон сувилахуйн үйлчилгээг өргөжүүлж, 45-аас дээш насны иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлэх “Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” аймгийн дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэх,

1.7. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэндийн төв байгуулахыг дэмжиж, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон эхчүүдийг нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлэх бодлого баримтлах,

1.8. Тендерийн шалгаруулалтыг олон нийтэд ил тод, нээлттэй хэлбэрээр явуулж, шударга өрсөлдөөнийг бий болгож, шалгаруулалтад ялсан гүйцэтгэгч нь ажлынхаа үр дүнг тооцох, гэрээнд заасны дагуу хариуцлагын тогтолцоог бий болгох талаар санаачилгатай ажиллах,

1.9. “Хүний хөгжил” аймгийн дэд хөтөлбөрийг батлан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах,

1.10. “Залуучуудын боловсрол, хөгжил” хөтөлбөрийг баталж, залуучуудын хүмүүжил, төлөвшилд үндэсний өв уламжлал, урлаг соёлоор дамжуулан эерэгээр нөлөөлөх бодлого баримтлах,

1.11. Үндэсний уламжлалт болон орчин үеийн мэдлэгийг дээдэлж, соёл урлаг, нийтийн биеийн тамир, спортыг дэмжин хөгжүүлэх, орчин үеийн аливаа мэдлэг, бүтээлийг дэмжиж, зах

зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, соёлын өвийг хадгалах, судлах, сурталчлах, эрхэмлэн дээдлэх, соёлтой харилцааны нийтлэг хэм хэмжээг төлөвшүүлэх бодлого баримтлах,

## **ХОЁР. ХОТ БАЙГУУЛАЛТ, ТОХИЖИЛТ, ЭКОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР**

Дарханчуудын эрүүл, аюулгүй ажиллаж амьдрах тохилог орчин нөхцлийг хангасан хот, суурин газрыг төлөвлөж, байгаль орчин хүний эрүүл мэндийн шаардлагад нийцсэн барилгын үйлдвэрлэлийг дэмжиж, байгалийн тэнцвэр алдагдахаас хамгаалж, байгаль хамгаалахад иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлнэ.

2.1. Дархан-Уул аймгийн хөгжлийн цогц бодлого, хот төлөвлөлтийн ерөнхий төлөвлөгөөг иргэдийн саналд тулгуурлан тодотгож, хотын барилгажилтын чиг хандлага, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнүүдийг батлаж хэрэгжүүлэх,

2.2. Хотын ерөнхий төлөвлөлтийг сайжруулж, “Миний гэр-Миний байр”, Жишиг хороолол”, “Тохилог хороолол” төслүүдийг хэрэгжүүлж, гэр хорооллын дэд бүтцийг сайжруулж, иргэдийн санал санаачилгад тулгуурлан хөгжүүлэх бодлого баримтлах,

2.3. Газрын бүсчлэл, үнэлгээний системийг боловсронгуй болгон, газрын харилцааны шинэчлэлт, газрын нэгдсэн сангийн тооллого хийж, иргэдэд шинээр газар өмчлүүлэх ажлыг цахим хэлбэрээр зохион байгуулахыг бодлогоор дэмжих, хяналт тавьж ажиллах,

2.4. Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн зайлшгүй шаардлага, ард иргэдийн хэрэгцээнд үндэслэн нутаг дэвсгэрийн хөгжлийн бодлогыг зөв тодорхойлоход мэргэжилтнүүд, иргэд, эрдэмтэн мэргэд, шинжээчдийн саналыг тусгах, бүсийн аймгуудтай эдийн засаг, нийгэм, байгаль орчны хамгаалалтын чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэх бодлого баримтлах,

2.5. Орон сууцны хорооллын болон гэр хорооллын дахин төлөвлөлт, инженерийн нэгдсэн хангамжийг сайжруулах, хотын төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэх бодлого баримтлах,

2.6. Орон нутгийн авто замыг сайжруулах хөтөлбөрийг хэрэгжүүлж, хотын нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, зам засварын ажлын чанарыг сайжруулж, хариуцлагын тогтолцоог нэвтрүүлэх бодлого баримтлах,

2.7. Хот орчмын ногоон бүсийг хамгаалалтанд авах, нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламжийг нэмэгдүүлэн арчлан хамгаалж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг урамшуулах тогтолцоог бий болгох,

2.8. Ундны усны эх үүсвэр болон усны нөөцийн хомсдол, бохирдлоос хамгаалах арга хэмжээг сайжруулан, эко систем, унаган байгалийн тогтвортой байдлыг хангах,

2.9. Агаарын бохирдлоос хамгаалах, утаагүй зуух, бүрэн шаталттай түлшээр хангах ажлыг дэмжиж, экологийн хувьд “Эрүүл хот” болгох зорилтыг хэрэгжүүлэх,

2.10. Аймгийн хэмжээнд байгалийн гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, хор хөнөөлийг арилгах, нөхөн сэргээх чадавхийг нэмэгдүүлэх,

2.11. Байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, ан амьтны мэдээллийн сантай болж ховор, нэн ховор амьтдыг хамгаалах, элсний нүүдэл цөлжилтөөс сэргийлэх зорилгоор “Ногоон хувьсгал” хөтөлбөрийг батлаж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах,

2.12. Байгаль хамгаалахад иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлж, “Өсвөрийн байгаль хамгаалагч” дэд хөтөлбөрийг баталж, экологийн хувьд эрүүл хот болох зорилгоор “Шарилжгүй Дархан” хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах,

2.13. Ойн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, ойг нөхөн сэргээх, ойжуулах замаар ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлэх, зүй зохистой тогтвортой ашиглахад чиглэсэн ойн тогтвортой цогц менежментийг хэрэгжүүлэх бодлого баримтлах,

2.14. Аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого батлан, орон нутгийн онцлог, давуу талд тулгуурласан аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг дэмжих,

## **ГУРАВ. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР**

Хүнс, хөдөө аж ахуйн салбарт шинэ техник технологийг нэвтрүүлэх, үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, эрсдэлийг бууруулах цогц арга хэмжээг дэмжиж, аймгийн хүн амын хүнсний хэрэгцээг экологийн чанартай бүтээгдэхүүнээр хангахад чиглэгдэнэ.

3.1. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг газар тариалантай зөв хослуулж, эрчимжүүлэн хөгжүүлэх, мал аж ахуйд биотехнологийн ололтыг нэвтрүүлж, мал үржүүлгийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг өргөжүүлэх замаар малын үржлийн чанарыг сайжруулж, ашиг шимийг нэмэгдүүлэх,

3.2. Мал эмнэлгийн үйлчилгээний чадавхийг сайжруулж, лабораторийн үйл ажиллагааг өргөжүүлэх,

3.3. Усалгаатай газар тариаланг хөгжүүлж, аймгийн хүн амын үр тариа, төмс, хүнсний ногооны хэрэгцээг бүрэн хангаж, зах зээлд нийлүүлэх нөхцлийг бүрдүүлэх

3.4. Өрхийн тариаланг өргөжүүлж, эрчимжүүлэн хөгжүүлэх, жимс, жимсгэний тариалалт, нэр төрлийг нэмэгдүүлэх,

3.5. Хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хүнсний ногоог дахин боловсруулах “Орхон кластер” төслийг дэмжих,

3.6. Аймгийн хүн амыг эрүүл, аюулгүй, тэжээллэг хүнсний бүтээгдэхүүнээр хангах ажлыг дэмжиж, тахиа, гахай, зөгийн аж ахуй аймгийн дэд хөтөлбөрүүдийг батлан, бүтээгдэхүүний борлуулалт, нийлүүлэлт, хүртээмжийг нэмэгдүүлэх,

## **ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР**

Аймгийн төсөв, санхүү, татварын бодлогыг оновчтой тодорхойлж, аймаг, орон нутгийнхаа санхүү, эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх, хувийн хэвшлийг дэмжин хөгжүүлэхэд чиглэгдэнэ.

4.1. Орон нутгийн төсвийн тогтвортой, бие даасан байдлыг бэжжүүлж, санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэхэд дотоод болон



гадаад эх үүсвэрүүдийн таатай боломжуудыг бүрэн дүүрэн ашиглах арга хэмжээг хэрэгжүүлэх бодлого баримтлах,

4.2. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаас тогтоодог татвар, төлбөр, хураамжийг орон нутгийн онцлогт тохируулан шинэчлэн тогтоож, татварын бааз суурийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн таатай орчныг бүрдүүлэх,

4.3. Төсвийн нээлттэй, ил тод байдлыг хангаж, хөрөнгө оруулалтыг иргэдийн оролцоотойгоор шийдвэрлэж, аймгийн төсвийн зарцуулалтанд Төлөөлөгчид, иргэдийн оролцоотойгоор хяналт тавьж, үр ашгийг нь дээшлүүлэх,

4.4. Шинжлэх ухаан, мэдээлэл технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжих чиглэлийг баримталж бодитой бүтээгдэхүүн, үйлчилгээ, эд баялаг, бүтээмж, ашиг орлогыг нэмэгдүүлэх чадварыг хөгжүүлэх,

4.5. Баялаг бүтээгчид, жижиг, дунд үйлдвэрлэл, фермерийн болон эрчимжсэн хөдөө аж ахуй, газар тариаланг зөв хослуулан хөгжүүлэхийг дэмжиж, Монгол хүний чадавхид тулгуурлан олон улсын түвшинд өрсөлдөхүйц бүтээгдэхүүн үйлдвэрлэх бодлого баримтлах,

4.6. Эдийн засгийн хувьд үр ашигтай, хөрсний үржил шимд ээлтэй таримал сортыг нутагшуулан үрийн сорт, чанарыг сайжруулах, “Бордоо” төслийг хэрэгжүүлж, үрийн тариаланг хөгжүүлэхийг бодлогоор дэмжих,

4.7. Энхийг эрхэмлэсэн, олон тулгуурт гадаад бодлогыг баримталж эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг бүх талаар хөхүүлэн дэмжих, олон улсын санхүү, хамтын ажиллагааны байгууллагуудтай тогтоох харилцааг эрчимжүүлж, сайн хөршийн харилцаатай орнуудтай харилцаагаа өргөжүүлэх,

4.8. Орон нутгийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүртгэл, хяналт, зарцуулалтыг сайжруулж, үр ашгийг дээшлүүлэх бодлого барьж, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд хяналт тавих,

## ТАВ. ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭ

Иргэдэд хууль тогтоомжийг сурталчлах, таниулах, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, Нутгийн удирдлагын байгууллагын үйл ажиллагааг сайжруулж, төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй шударга, шуурхай байдлыг хангуулж хууль дээдэлсэн төрт ёсыг бэхжүүлэхэд чиглэгдэнэ.

5.1. Монгол улсын хуулиудад орон нутгийн болон иргэдийн амьдрал, эрх ашгаас урган гарсан саналуудыг тусгуулах, хууль тогтоомж болон гарсан шийдвэрийг сурталчилах, таниулах, хэрэгжилтийг хангуулах,

5.2. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын үйл ажиллагаанд мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хэвшүүлж, мэдээллийг тэгш хүртээмжтэй олж авах нөхцлийг хангуулж, иргэн төвтэй төрийн үйлчилгээг дээдлэн хэрэгжүүлэх

5.3. Иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагуудтай нягт хамтран ажиллаж Төлөөлөгчид болон ТАХ-дыг судлаач, суралцагч, хөгжлийг тодорхойлогч болгох зорилтыг тавьж ажиллах,

5.4. Аймгийн бодлого, шийдвэрт иргэдийн байр суурь, үзэл бодол, санал санаачилгыг тусгах зорилгоор “Иргэний танхим”-ын нээлттэй хэлэлцүүлэг хийх, санал асуулга явуулах, судалгаа авах, хууль тогтоомжийг сурталчлах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх бодлого баримтлах,

5.5. Иргэдийн амгалан тайван ажиллах амьдрах нөхцлийг бүрдүүлэх, гэмт хэрэг, ашиг сонирхолын зөрчил, архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг батлан, хууль хяналт, иргэний нийгмийн байгууллага болон иргэдийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх,

5.6. Сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, багийн Иргэдийн Нийтийн Хурлын ажилд мэргэжил арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлж, Хурлын боловсон хүчнийг мэргэшүүлэх, сургах, чадваржуулах тодорхой ажил зохион байгуулж, ажиллах нөхцлийг сайжруулах,

5.7. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийг чадавхижуулах, хөгжсөн орнуудын болон бусад аймгуудын туршлагаас суралцах боломжийг олгох, цаг үеийн мэдээ мэдээллээр хангах, сургалт семинарыг тогтмол зохион байгуулах.

## АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2016 оны 10 сарын 06 өдөр

Дугаар 3/03

Дархан

Дархан-Уул аймгийн Засаг даргын  
2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр  
батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ийн "а", 19 дүгээр зүйлийн 19.1, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалтуудыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус Гуравдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. "Аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг хавсралтаар баталсугай.

2. Аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга /С.Насанбат/-д даалгасугай.

а/ Аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хөтөлбөрийн биелэлтийг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж байх;

б/ Аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дөвшүүлсэн зорилтыг жил бүрийн төсвийн хүрээний мэдэгдэл, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэх.

ДАРГА  Г.ЭРДЭНЭБАТ

D:\document\hural document\toztool

Аймгийн ИТХ-ын 2016 оны ээлжит бус Гуравдугаар  
хуралдааны 3/03 дугаар тогтоолын хавсралт

## **ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2017-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР**

Иргэдийнхээ хэрэгцээ шаардлагад тулгуурлан хүсэл зоригийг нь эрхэмлэн дээдэлж, аймгийн эдийн засаг, нийгмийг эрчимтэй хөгжүүлэхэд төрийн бодлого, үйл ажиллагааг чиглүүлнэ.

### **НЭГ. ТӨРИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО**

Төрийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг иргэдэд тэгш, шударга, хүртээмжтэй, нээлттэй, ил тод, шуурхай хүргэнэ.

1.1. Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдал, удирдлагын манлайлал, салбар хоорондын уялдааг сайжруулж, шийдвэр гаргахад бүх талын оролцоог хангана.

1.2. Иргэн төвтэй төрийн үйлчилгээг дээдэлж, бүх шатны төрийн үйлчилгээг иргэдэд шударга, хүртээмжтэй, хүнд сурталгүй, хөнгөн шуурхай хүргэнэ.

1.3. Нийгэм, эдийн засгийн зарим чухал асуудлаар шийдвэр гаргахдаа иргэд, олон нийтийн саналыг авч, нийгмийн бүлгүүдийн оролцоонд тулгуурлаж, олонхийн эрх ашгийг дээдэлсэн зөв бодлого гаргаж, хэрэгжүүлнэ.

1.4. “Ухаалаг Дархан” аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

1.5. Аймгийн Засаг даргын Тамгын газарт нэвтрүүлсэн Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015/MNS ISO 9001:2016 стандартын хэрэгжилтийг байнга сайжруулж, зарим сум, байгууллагад нэвтрүүлэх замаар төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.6. Төрийн байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлэх замаар төрийн албан хаагчдын ажиллах орчныг сайжруулна.

1.7. Төрийн албан хаагчдыг чадавхижуулах, нийгмийн баталгааг хангах замаар төрийн албаны тогтвортой байдлыг хадгална.

1.8. Иргэдэд үзүүлэх төрийн анхан шатны үйлчилгээг чанаржуулах зорилгоор багийн хөгжлийг дэмжинэ.

1.9. Үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцооны чадавхийг дээшлүүлнэ.

1.10. Төрийн бус байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлнэ.

1.11. Гадаад бодлогын нэгдмэл байдал, залгамж чанарыг хадгалж, эдийн засаг, нийгмийн бүхий л салбарт гадаад харилцааг өргөжүүлэн хөгжүүлнэ.

1.12. Гадаад улс орнуудын мэргэжлийн байгууллагатай орон нутгийн аж ахуйн нэгж байгууллагуудыг хамтран ажиллуулах, туршлага солилцуулах талаар төрөөс бодлогоор дэмжинэ.

## **ХОЁР. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГО**

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулж, авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тууштай тэмцэж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх замаар иргэдийн аюулгүй орчинд тайван амьдрах баталгааг хангана.

2.1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, биелэлтэд тавих хяналтыг сайжруулна.

2.2. Эрх зүйн сургалт, сурталчилгааг шинэлэг хэлбэрээр зохион байгуулж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хууль зүйн мэдлэг олгох, туслалцаа үзүүлэх ажлыг чанаржуулна.

2.3. “Иргэний эрх зүйн боловсрол” аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

2.4. “Архигүй Монгол хүн” аймгийн дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

2.5. Иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж ажиллана.

2.6. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, гэмт хэргийн гаралтыг бууруулна.

2.7. Авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэж, орон нутгийн төрийн албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлнэ.

2.8. Төрийн захиргааны болон хууль, хяналтын байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулна.

2.9. Шүүхийн шинжилгээний албаны үзлэг шинжилгээний чанарыг дээшлүүлж, гэмт хэргийн илрүүлэлтийн түвшинг ахиулна.

2.10. Оюуны өмч, бүртгэл, мэдээллийн үйл ажиллагааг иргэдэд нээлттэй, үнэн зөв, нэгдсэн, шуурхай хүргэж, иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхол, өмчлөх эрхийг хангаж ажиллана.

2.11. Төрийн архив, албан хэрэг хөтлөлт, архивын баримтын хадгалалт, хамгаалалт, нөхөн бүрдүүлэлт, ашиглалтын үйл ажиллагааг сайжруулна.

## **ГУРАВ. ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ**

Эдийн засгийн зохистой бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлснээр тогтвортой хөгжлийг хангана.

### **3.1. БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

Аймгийн хөгжлийн баримт бичгүүдийг шинэчлэн боловсруулж, эдийн засгийн үр ашигтай бодлого, үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ.

3.1.1. Аймгийн хөгжлийн цогц бодлого /2009-2021 он/-ыг тодотгож, хэрэгжилтийг хангуулна.

3.1.2. Аймгийн хөгжлийн урт хугацааны бодлого /2016-2030 он/-ын баримт бичгийг боловсруулж, хэрэгжилтийг хангуулна.

3.1.3. Хот төлөвлөлтийн ерөнхий төлөвлөгөө /урт хугацааны/-г боловсруулж, хэрэгжүүлнэ.

3.1.4. Хотын үндсэн тосгон, хуучин суурьшлын бүсийн дахин төлөвлөлтийг хийнэ.

3.1.5. “Хотын дүрэм”-ийг боловсруулж, хэрэгжилтийг хангуулна.

3.1.6. Аймгийн хэмжээнд шинээр үүсэж байгаа суурьшлын

бүсэд байр зүйн зураг /М1:1000/ хийлгэнэ.

3.1.7. “Орон сууц” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.

3.1.8. Орон сууцны хороололд “Жишиг хороолол” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

3.1.9. Гэр хороололд “Тохилог хороолол” төслийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

3.1.10. Сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор “Миний гэр-Манай байр” аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

3.1.11. Дархан суманд иргэд, олон нийтийн соёл, амралтын цэцэрлэгт хүрээлэн байгуулна.

## 3.2. ДЭД БҮТЭЦ

Аймгийн хэмжээнд дэд бүтцийн салбарыг эрчимтэй хөгжүүлж, хөгжлийн таатай орчныг бүрдүүлнэ.

3.2.1. Аймгийн хэмжээнд цахилгаан, дулаан хангамжийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, эрчим хүчний найдвартай ажиллагааг хангуулна.

3.2.2. Аймагт эрчим хүчний 2 дахь эх үүсвэр байгуулах бэлтгэл ажлыг хангуулна.

3.2.3. Сумдын ундны усны эх үүсвэр, төвлөрсөн усан хангамж, ариутгах татуурга, шугам хоолой, цэвэрлэх байгууламжийг шинэчилж, өргөтгөнө.

3.2.4. “Орон нутгийн авто замыг сайжруулах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ.

3.2.5. Аймгийн авто тээврийн салбарыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө, стратегийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

3.2.6. Орон нутгийн авто зам, замын байгууламж, тээврийн үйлчилгээг хариуцсан мэргэжлийн байгууллага байгуулж ажиллуулна.

3.2.7. Аймгийн хэмжээнд хатуу хучилттай замыг шинэчлэн сайжруулна.

3.2.8. “Дархан-Шарын гол” чиглэлийн авто замыг хатуу



хучилттай болгоно.

3.2.9. “Барилгачдын өргөн чөлөө”-ний 8,2 км төв авто замыг үргэлжлүүлэн барьж дуусгана.

3.2.10. Үерийн далан, сувагжуулалтын байгууламжийг засварлаж, өргөтгөнө.

3.2.11. Иргэдийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн нийтийн тээврийн үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлнэ.

### 3.3. ҮЙЛДВЭРЖИЛТ

Аж үйлдвэрийн салбарт дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлнэ.

3.3.1. “Дархан үйлдвэрлэл, технологийн парк”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын бизнес эрхлэх, хамтран ажиллах таатай орчин нөхцлийг бүрдүүлнэ.

3.3.2. Орон нутаг дахь байгалийн түүхий эдийн нөөцөд тулгуурлан барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

3.3.3. Төмөртэй, Төмөр толгойн ордуудыг ашиглаж Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг цогцолбор хэлбэрээр өргөжүүлнэ.

3.3.4. Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн цогцолборыг дагасан жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, орон нутгийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг хөгжүүлнэ.

3.3.5. Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэр болон нүүрсний нийлэг хийн үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжинэ.

3.3.6. Оёмол, нэхмэл, сүлжмэл зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжинэ.

3.3.7. Арьс, шир, ноос, ноолуур зэрэг малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг байгальд ээлтэй цогцолбор хэлбэрээр хөгжүүлнэ.

3.3.8. Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэдийг шаардлагатай мэдээ, мэдээлэл, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг гадаадын зах зээлд гаргахыг бодлогоор дэмжинэ.

3.3.9. Худалдаа, үйлчилгээний салбарыг төрөлжүүлэн хөгжүүлж, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.

3.3.10. Алслагдсан багт “Ахуйн үйлчилгээний нэгдсэн цэг” байгуулна.

## **ДӨРӨВ. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГО**

Хүнс, хөдөө аж ахуйн салбарт шинэ техник, технологийг нэвтрүүлэх, үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, эрсдлийг бууруулах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлснээр аймгийн хүн амын хүнсний хэрэгцээг экологийн чанартай бүтээгдэхүүнээр тасралтгүй хангаж, гадаад, дотоодын зах зээлд нийлүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.

### **4.1. МАЛ АЖ АХУЙ**

Мал аж ахуйг газар тариалантай зөв хослуулан хөгжүүлснээр бэлчээрийн даацад тохирсон суурин, хагас суурин хэлбэрийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн загварт үе шаттайгаар шилжүүлнэ.

4.1.1. Хонгор сумын нутагт шинээр баригдах “Малын удмын сангийн Үндэсний цогцолбор”-ын бүтээн байгуулалтын ажилд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

4.1.2. Тахиа, гахай, зөгийн аж ахуй зэрэг аймгийн дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, бүтээгдэхүүний нийлүүлэлт, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

4.1.3. Аймгийн хэмжээнд бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, фермерийн аж ахуйг зохистойгоор хослуулан хөгжүүлнэ.

4.1.4. Мал аж ахуйд биотехнологийн ололтыг нэвтрүүлж, малын үржлийн чанарыг сайжруулж, ашиг шимийг нэмэгдүүлнэ.

4.1.5. Мал эмнэлгийн үйлчилгээний чадавхи, хүртээмжийг сайжруулж, лабораторийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.

4.1.6. Мал, түүхий эдийн төвлөрсөн зах байгуулахыг бодлогоор дэмжинэ.

## 4.2. ГАЗАР ТАРИАЛАН

Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлж, нэгж талбайн ургацыг нэмэгдүүлнэ.

4.2.1. Усалгаатай газар тариаланг хөгжүүлж, газар тариалангийн техник, технологийн шинэчлэлийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

4.2.2. Үрийн сорт, чанарыг сайжруулах зорилгоор “Дархан үр” аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

4.2.3. Хөрсний үржил шимийг сайжруулах зорилгоор “Бордоо” төслийг хэрэгжүүлнэ.

4.2.4. Аймгийн хүн амын үр тариа, төмс, хүнсний ногооны хэрэглээг бүрэн хангаж, газар тариалангийн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.

4.2.5. Тариалангийн газрыг эдийн засгийн эргэлтэд бүрэн оруулж, үр ашигтай ашиглаж, газар тариалангийн бүтээгдэхүүний бүртгэл, хяналтыг сайжруулна.

4.2.6. Өрхийн тариаланг хөгжүүлэх зорилгоор “Ногоон хувьсгал” аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

4.2.7. Жимс, жимсгэний тариалалт, нэр төрлийг нэмэгдүүлнэ.

## 4.3. ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Аймгийн хүн амын хүнсний хэрэгцээг экологийн чанартай бүтээгдэхүүнээр тасралтгүй хангах нөхцлийг бүрдүүлнэ.

4.3.1. “Хүнсний хангамж, аюулгүй байдал” аймгийн дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

4.3.2. Хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

4.3.3. Хүнсний ногоог дахин боловсруулах “Орхон кластер” төслийг хэрэгжүүлж, орон нутагт жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлнэ.

4.3.4. Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын мэргэжлийн холбоодын үйл ажиллагааг дэмжиж, хүний нөөцийг чадавхижуулна.

4.3.5. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний борлуулалт, нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтарч ажиллана.

## **ТАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГО**

Байгаль орчинд ээлтэй бодлогыг боловсруулан хэрэгжүүлж, ногоон хөгжлийг дэмжиж, цөлжилтийг сааруулснаар экологийн тэнцвэртэй байдлыг хадгална.

### **5.1. БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ**

Байгаль хамгаалал, ашиглалт, нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд зүй зохистой хэрэгжүүлнэ.

5.1.1. Ойн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, ойн хомсдол, доройтлыг зогсоох, ойг нөхөн сэргээх, ойжуулах замаар ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлэх, зүй зохистой, тогтвортой ашиглахад чиглэсэн тогтвортой, цогц ойн менежментийг хэрэгжүүлнэ.

5.1.2. Усны нөөцийг хомсдол, бохирдлоос хамгаалах, боломжит нөөцийг зүй зохистой ашиглах замаар газар зохион байгуулалт, экосистем, унаган байгалийн тогтвортой байдлыг хангана.

5.1.3. Агаар, орчны чанарын төлөв байдлын мэдээллийг шуурхай хүргэж, агаарын чанар, бохирдлын хэмжээнд тогтмол тавих хяналтыг сайжруулна.

5.1.4. Уур амьсгалын ажиглалтын сүлжээг өргөтгөн технологийн шинэчлэл хийж, судалгаа, шинжилгээ, үнэлгээний ажлыг өргөжүүлнэ.

5.1.5. Бэлчээрийн төлөв байдал, цөлжилтийн судалгаа хийж, зайлшгүй шаардлагатай үед цаг агаарт зориудаар нөлөөлөх ажлыг зохион байгуулна.

5.1.6. Уул уурхай, ашигт малтмалын олборлолтод хяналт тавьж, ашиглаж байгаа болон орхигдсон талбайн нөхөн

сэргээлтийг үе шаттайгаар хийлгэнэ.

5.1.7. Тусгай хамгаалалтын газар нутгийн сүлжээг өргөтгөж, газар болон газрын хэвлийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

5.1.8. Хүүхэд, залуучуудад экологийн боловсрол олгох зорилгоор “Өсвөрийн байгаль хамгаалагч” аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

5.1.9. Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулж, байгальд ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.

5.1.10. “Эрүүл хот”, “Шарилжгүй Дархан”, “Утаагүй Дархан” аймгийн дэд хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

5.1.11. Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.

5.1.12. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр батлагдсан төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангуулна.

## 5.2. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогыг боловсруулж хэрэгжүүлснээр аймгийн эдийн засагт нөлөөлөхүйц салбарын нэг болгоно.

5.2.1. Орон нутгийн онцлог, давуу талд тулгуурласан аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ.

5.2.2. Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг дэмжиж ажиллана.

5.2.3. Аялал жуулчлалын маршрутын дагуух байгалийн дурсгалт газар, түүх, соёлын үнэт зүйлсийг сэргээн засварлах, хамгаалах ажлыг эрчимжүүлнэ.

## ЗУРГАА. НИЙГМИЙН БОДЛОГО

Нийгмийн салбарын бодлого, менежмент, чанарыг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

### 6.1. БОЛОВСРОЛ, СОЁЛ УРЛАГ, СПОРТ

Боловсролын үйлчилгээг төрийн бодлогод нийцүүлэн иргэдэд тэгш, хүртээмжтэй хүргэж, соёл урлаг, спортыг дэмжин хөгжүүлнэ.

6.1.1. Сургууль, цэцэрлэгийн менежмент, сургалтын чанарыг сайжруулж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

6.1.2. Төрийн өмчийн бүх сургуулиудыг бага, суурь, ахлах боловсролын хэв шинжид үе шаттайгаар шилжүүлнэ.

6.1.3. Сургууль, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлж, хүүхдийн сурах ая тухтай орчныг бүрдүүлнэ.

6.1.4. Бүх нийтийн боловсролыг дээшлүүлж, насан туршийн боловсролын тогтолцоог бий болгоно.

6.1.5. “Ном”, “Авьяас” аймгийн дэд хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

6.1.6. “Дарханы иргэд оюунлаг, авьяаслаг” аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

6.1.7. “Багшийн хөгжил” аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, багш, ажилтны мэргэжил, ур чадварыг сайжруулна.

6.1.8. Их, дээд сургуулиудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, эрдэмтэн багш нарын бүтээл, туурвилыг орон нутгийн бүтээн байгуулалт, хөгжилд бодитойгоор ашиглана.

6.1.9. Орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн мэргэжилтэй ажилтныг Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдтэй хамтран бэлтгэж, төгсөгчдийг ажлын байраар хангана.

6.1.10. Оюутан, залуучуудыг дэмжих зорилгоор “Залуучуудын боловсрол, хөгжил” аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

6.1.11. “Боловсрол хотхон”-ны бүтээн байгуулалтыг үе шаттайгаар үргэлжлүүлнэ.

6.1.12. “Хүүхдийн хөгжлийн ордон”-ны бүтээн байгуулалтыг үргэлжлүүлж, ашиглалтанд оруулна.

6.1.13. Мэргэжлийн болон сумдын соёл, урлаг, спортын байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлж, хүний нөөцийн чадавхийг сайжруулж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

6.1.14. “Спорт цогцолбор”-ын барилгын санхүүжилтийг шийдвэрлүүлэн ашиглалтад оруулж, иргэдийг спортоор хичээллэх таатай орчныг бүрдүүлнэ.

6.1.15. “Спортлог Дарханчууд” аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

6.1.16. Өвлийн спортын төрлүүдийг дэмжин хөгжүүлнэ.

## 6.2. ЭРҮҮЛ МЭНД

Эрүүл мэндийн салбарын менежмент, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

6.2.1. Хүн амын эрэлт хэрэгцээтэй уялдуулан тусламж үйлчилгээний төвлөрлийг сааруулж, урьдчилан сэргийлэх болон оношилгоо, эмчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

6.2.2. Эмнэлгийн тусламж үйлчилгээнд гарч буй хүлээгдлийг үе шаттайгаар бууруулна.

6.2.3. Эрүүл мэндийн байгууллагуудын материаллаг бааз, хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлж, үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх таатай орчныг бүрдүүлнэ.

6.2.4. Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг дэмжих замаар эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, хүүхдийн эндэгдлийг бууруулна.

6.2.5. Зонхилон тохиолдох халдварт бус өвчин, түүний эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй оролцоо, нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулна.

6.2.6. Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдлыг сайжруулж, халдварт өвчний тархалтыг бууруулна.

6.2.7. “Эрүүл Дарханчууд” аймгийн дэд хөтөлбөрийг

боловсруулж хэрэгжүүлнэ.

6.2.8. Сувилахуйн тусламж үйлчилгээг сайжруулж, эмнэлгийн дунд мэргэжлийн ажиллагсдын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд анхаарч ажиллана.

6.2.9. Эм зүйн салбарт орчин үеийн шинэ арга, технологийг нэвтрүүлнэ.

### 6.3. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллыг сайжруулна.

6.3.1. “Хүний хөгжил” аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

6.3.2. Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, байнгын ажлын байранд зуучлах замаар ажилгүйдлийн түвшинг бууруулна.

6.3.3. 45-аас дээш насны иргэдэд зориулсан ажлын байр бий болгох зорилгоор “Ахмадуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн дэд хөтөлбөр”-ийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

6.3.4. Иргэдэд хөдөлмөр, хөрөнгөөрөө хоршин ажиллах замаар орлогоо нэмэгдүүлэх боломж нөхцлийг бүрдүүлнэ.

6.3.5. Төр, иргэний нийгмийн байгууллагуудын түншлэлийг сайжруулна.

6.3.6. Аймгийн хэмжээнд хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт түншлэлийн харилцааг жишиг болохуйц түвшинд хүргэж хөгжүүлнэ.

6.3.7. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил хамгааллын талаарх төрийн бодлогын хэрэгжилтийг сайжруулна.

6.3.8. Ахмад настны нийгмийн хамгааллыг сайжруулж, өндөр настны эрүүл мэндийг дэмжих, нөхөн сэргээх төв /Герентологи/ байгуулна.

6.3.9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгааллыг сайжруулж, тэдэнд ээлтэй орчныг бүрдүүлнэ.

6.3.10. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хамрах хүрээг нэмэгдүүлж, эрсдлийг бууруулна.

6.3.11. Нийгмийн халамжийн зорилтот бүлгийн иргэдэд



чиглэсэн хөтөлбөр, төслийг боловсруулж хэрэгжүүлнэ.

6.3.12. Түр хамгаалах байрыг өргөтгөн үйл ажиллагааны чанар, цар хүрээг нэмэгдүүлж, хамтран ажиллахыг дэмжинэ.

## **ДОЛОО. САНХҮҮ, ТӨСВИЙН БОДЛОГО**

Төсвийн ил тод байдлыг хангаж, тогтвортой бие даасан байдлыг бэхжүүлэн орон нутгийн эдийн засгийн таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бодлогыг баримталж ажиллана.

7.1. Татвар төлөгчдөд төсвийн зарцуулалтанд хяналт тавих нөхцлийг бүрдүүлж, төсөв, санхүүгийн ил тод байдлыг холбогдох хууль эрх зүйн хүрээнд ханган ажиллана.

7.2. Орон нутгийн төсвийн цахим төлөвлөлтийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийг хангуулан төсвийн хяналтыг сайжруулна.

7.3. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаас тогтоодог татвар, төлбөр, хураамжийг орон нутгийн онцлогт тохируулан шинэчлэн тогтоож, татварын бааз суурийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн таатай орчныг бүрдүүлнэ.

7.4. Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан хүлээн авалтын хувь хэмжээг нэмэгдүүлж, бүртгэл хөтлөлтийг сайжруулна.

7.5. Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлж ажиллана.

7.6. Статистик мэдээ, мэдээллийн үнэн зөв, ил тод, хараат бус, бие даасан зарчмыг хангуулж ажиллана.

7.7. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавина.

7.8. Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхийг дэмжиж ажиллана.

## НАЙМ. ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГО

Нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулна.

8.1. Байгалийн аюулт үзэгдэл, болзошгүй гамшгийг тандан судлах, урьдчилан мэдээлэх, тогтолцоог орон нутагт бүрдүүлж, гамшгийн эрсдэл, эмзэг байдал, хохирлыг бууруулах зорилгоор олон нийтэд тулгуурласан удирдлагын тогтолцоог, нэвтрүүлэн гамшигтай тэмцэх чадавхийг бэхжүүлнэ.

8.2. Гамшгаас хамгаалах байгууллагын материаллаг баазыг нэмэгдүүлж, гамшигтай тэмцэх бэлтгэл, бэлэн байдлын чадавхийг сайжруулна.

8.3. Гамшгийн үед тохиолдох эрсдлийг бууруулж, ажиллах бие бүрэлдэхүүний ажлын байрны болон эрүүл ахуйн нөхцлийг сайжруулна.

8.4. Цэргийн алба хаах зөвшөөрөгдсөн хэлбэрүүдийг зохистой хэрэгжүүлж, иргэний цэргийн үүргийн биелэлтийг хангуулж ажиллана.

8.5. Цэргийн үүрэгтэн цугларах, техник шилжүүлэх байрын сургалт, дадлагыг чанаржуулж, техник хэрэгслээр хангана.

8.6. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнтэй явуулах сургалтын чанарыг сайжруулж, холбогдох техник хэрэгслээр хангана.

Нийт 8 бүлэг, 11 дэд бүлэг, 139 зорилт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

## ШИНЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

### Төрийн удирдлагын бодлогын чиглэлээр

1. “Ухаалаг Дархан” аймгийн дэд хөтөлбөр

### Хууль, эрх зүйн бодлогын чиглэлээр

2. “Иргэний эрх зүйн боловсрол” аймгийн дэд хөтөлбөр

### Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр

3. “Эрүүл хот” аймгийн дэд хөтөлбөр
4. “Ногоон хувьсгал” аймгийн дэд хөтөлбөр
5. “Миний гэр-Манай байр” аймгийн дэд хөтөлбөр
6. “Өсвөрийн байгаль хамгаалагч” аймгийн дэд хөтөлбөр
7. “Дархан үр” аймгийн дэд хөтөлбөр
8. Тахиа, гахай, зөгийн аж ахуй зэрэг аймгийн дэд хөтөлбөрүүд

### Нийгмийн бодлогын чиглэлээр

9. “Хүний хөгжил” аймгийн дэд хөтөлбөр
10. “Эрүүл Дарханчууд” аймгийн дэд хөтөлбөр
11. “Дарханы иргэд оюунлаг, авьяаслаг” аймгийн дэд хөтөлбөр
12. “Залуучуудын боловсрол, хөгжил” аймгийн дэд хөтөлбөр
13. “Ахмадуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн дэд хөтөлбөр”
14. “Спортлог Дарханчууд” аймгийн дэд хөтөлбөр
15. “Багшийн хөгжил” аймгийн дэд хөтөлбөр

## ҮРГЭЛЖЛҮҮЛЭН ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

### Хууль, эрх зүйн бодлогын чиглэлээр

1. “Архигүй Монгол хүн” аймгийн дэд хөтөлбөр

### Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр

2. “Орон сууц” дэд хөтөлбөр
3. “Орон нутгийн авто замыг сайжруулах хөтөлбөр”
4. “Хүнсний хангамж, аюулгүй байдал” аймгийн дэд хөтөлбөр
5. “Шарилжгүй Дархан” аймгийн дэд хөтөлбөр

### Нийгмийн бодлогын чиглэлээр

6. “Ном” аймгийн дэд хөтөлбөр
7. “Авьяас” аймгийн дэд хөтөлбөр

## ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

1. Аймгийн хөгжлийн цогц бодлого /2009-2021 он/-д тодотгол хийх
2. Аймгийн хөгжлийн урт хугацааны бодлого /2016-2030 он/ боловсруулах
3. Хот төлөвлөлтийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах /урт хугацааны/
4. “Хотын дүрэм” боловсруулж, батлуулах

## ТОМООХОН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ЖАГСААЛТ

1. Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэр байгуулах
2. Хог хаягдал боловсруулах үйлдвэр байгуулах
3. Өндөр настны эрүүл мэндийг дэмжих, нөхөн сэргээх төв /Герентологи/ байгуулах
4. “Спорт цогцолбор”-ын барилгын бүтээн байгуулалтыг үргэлжүүлж, ашиглалтанд оруулах
5. Сургууль, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх
6. “Боловсрол хотхон” байгуулах
7. “Хүүхдийн хөгжлийн ордон”-ны барилгын бүтээн байгуулалтыг үргэлжлүүлж, ашиглалтанд оруулах
8. Соёл, амралтын цэцэрлэгт хүрээлэн байгуулах
9. “Ахуйн үйлчилгээний нэгдсэн цэг” байгуулах
10. Авто тээврийн салбарын мэргэжлийн байгууллага байгуулах
11. “Дархан-Шарын гол” чиглэлийн авто замыг хатуу хучилттай болгох
12. “Барилгачдын өргөн чөлөө”-ний 8,2 км хатуу хучилттай авто зам барьж дуусгах
13. Мал, түүхий эдийн төвлөрсөн зах байгуулах

## ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН ЖАГСААЛТ

1. “Орхон кластер” төсөл
2. “Жишиг хороолол” төсөл
3. “Тохилог хороолол” төсөл
4. “Бордоо” төсөл